



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/192

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "А", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалт, аймгийн Онцгой комиссын хуралдааны 2021 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 30 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал, хязгаарлалтын дэглэмийн үед үүрэг гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчдын хоол хүнс, шатахуун, тусгаарлах байр болон хяналтын цэгүүдтэй холбоотой зардал, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хурдавчилсан тест, хамгаалах хувцас, хэрэгсэл зэрэг бараа материалын худалдан авалт, зарцуулалтанд санхүүгийн аудит хийх, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Өөдэй - Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга

Гишүүд:

Ц.Цэцэнхараацай -Санхүүгийн хяналт шалгалтын
улсын байцаагч

Б.Батзол -Санхүүгийн хяналт, аудитын албаны дотоод аудитор

С.Дорж -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн

дарга: П.Мягмартүвшин -Санхүүгийн хяналт шалгалтын
улсын байцаагч

2.Тайлангийн аудит, хяналтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж 7 хоног бүр аймгийн Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Г.Өөдэй/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/192 Ch
02 1127